

**XXI зууны боловсролын парадигм: баримт бичгийн
философи шинжилгээ**

Бат-Өлзий Батзаяа 

*Монгол Улсын Боловсролын их сургуулийн, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн багш, магистр, Улаанбаатар, Монгол Улс*

Хүлээн авсан - Received:
2025- 11-15

Засварласан - Revised:
2025-12-25

Хэвлэгдсэн – Published:
2025-12-31

batzaya.b@msue.edu.mn
ORCID: [0009-0002-0294-9052](https://orcid.org/0009-0002-0294-9052)



© 2025, Author(s)

Хураангуй. Энэхүү өгүүлэлд XXI зууны боловсролын парадигмын философи үндэслэлийг олон улсын боловсролын бодлого, үзэл баримтлалын баримт бичгүүдэд тулгуурлан шинжилсэн болно. Судалгааны зорилго нь ЮНЕСКО-оос боловсруулсан “Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь: Боловсрол бүх нийтийн баялаг мөн үү?”, “Тогтвортой хөгжлийн боловсрол: Замналын зураглал”, “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ” зэрэг суурь баримт бичгүүдэд илэрч буй XXI зууны боловсролын парадигмыг тодорхойлж буй философи үндэслэлийг илрүүлэхэд оршино. Судалгаанд баримт бичгийн философи шинжилгээ, харьцуулалт, герменевтик тайлал зүйн аргуудыг хослуулан хэрэглэж, философийн антропологи, онтологи, гносеологи, аксиологийн шалгуурын дагуу

шинжилгээ хийв. Шинжилгээний үр дүнд XXI зууны боловсролын парадигм нь хүнийг эрх чөлөөтэй, хариуцлагатай, хамтын оршихуйд идэвхтэй оролцогч, утга бүтээгч субъект хэмээн тодорхойлсон философийн антропологийн үзэлд тулгуурлаж буй нь тогтоогдов. Онтологийн түвшинд оршихуйг нийгэм, соёл, байгаль, технологийн харилцан хамаарал бүхий динамик тогтолцоо гэж үзэж, боловсролыг тогтвортой ирээдүйг хамтдаа бүтээх суурь хэрэгсэл хэмээн тайлбарлаж байна. Гносеологийн хувьд мэдлэгийг хамтын оролцоо, шүүмжлэлт сэтгэлгээ, туршлагад суурилсан, насан туршийн тасралтгүй үйл явц гэж тодорхойлсон бол, аксиологийн түвшинд хүний эрх, шударга ёс, хамтын сайн сайхан, тогтвортой хөгжлийг суурь үнэт зүйл болгон дэвшүүлж байна. Ийнхүү XXI зууны боловсролын парадигм нь сонгодог бус болон сонгодог бусын дараах философийн урсгал, чиглэлүүдийн үзэл санааны интеграцид тулгуурласан, уян хатан, нээлттэй, динамик философи баримтлал болохыг судалгааны үр дүн харуулж байна.

Түлхүүр үг. боловсролын парадигм, парадигмын өөрчлөлт, боловсролын философи үндэслэл, философийн антропологи, онтологи, гносеологи, аксиологи.

Судалгааны онол-арга зүйн үндэслэл. Боловсролын парадигм, түүний философи үндэслэлийг судлахад герменевтик-тайлал зүй, бүтэц зүй, баримт бичгийн философи шинжилгээ зэрэг арга, аргачлалыг хослуулсан ашиглав. Герменевтик тайлал зүйн арга нь баримт бичгийн утга, үзэл санааг философийн түвшинд тайлбарлахад, бүтэц зүйн арга нь парадигмын бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа, хамаарлыг шинжлэхэд, харин баримт бичгийн философи шинжилгээ нь боловсролын баримт бичгүүдэд илэрсэн философийн чиг хандлагыг тодруулахад тус тус чиглэнэ.

Баримт бичгийн философи шинжилгээ хийх шалгуур, чиглэл: Баримт бичигт философи шинжилгээ хийх арга зүй нь ердийн контентын анализ эсвэл эмпирик судалгаанаас ялгаатай бөгөөд ойлголт төвтэй, үнэт зүйл, логик дараалал, үзэл баримтлалыг системтэй задлан

шинжлэхэд чиглэгддэгээрээ онцлогтой. Тиймээс баримт бичигт дараах шалгууруудын дагуу харьцуулан шинжилж, холбогдох тайлбар, дүгнэлтийг хийв. Үүнд:

- 1) Философийн антропологи (Хүний мөн чанар, оршихуйг хэрхэн авч үзвэл зохистой вэ?)
- 2) Онтологи (Хүний үзлийн чиг баримжаа, хүн ба ертөнцийн харилцаа хэрхэн өөрчлөгдөн байна вэ?)
- 3) Гносеологи (Мэдлэгийн мөн чанар, түүнийг бүтээх танин мэдэхүйн үйл явц хэрхэн өөрчлөгдөж байна вэ?)
- 4) Аксиологи (Хүний үнэт зүйлсийн тогтолцоо хэрхэн хувьсан шинэчлэгдэж, тэргүүлэх үнэлэмж нь юу болж байна вэ?) гэсэн шалгуурыг ашиглав.

Эдгээр шалгуурын тайлбарыг дараах хүснэгтээр үзүүлж байна.

Хүснэгт 1. Шалгуурын тайлбар

Шалгуур	Шалгуурыг сонгосон зорилго
Философийн антропологи	Хүнийг хэрхэн ойлгож, хүний ямар загварыг дэвшүүлж байгааг илрүүлнэ. Тус судалгаанд суурь шинжтэй шалгуур юм.
Онтологи	Хүн ямар оршихуйн хүрээнд төлөвшиж, ертөнц, хүн, нийгмийн харилцааг хэрхэн ойлгож байгааг тодорхойлно.
Гносеологи	Мэдлэгийг хэрхэн ойлгож, суралцах үйл явцыг ямар онолд тулгуурлан тодорхойлж байгааг шинжилнэ.
Аксиологи	Боловсролоор дамжуулан түгээн дэлгэрүүлж буй үнэт зүйлийн суурь, үнэлэмжийн хүрээг шинжилнэ.

Оршил. XXI зуун бол хүн төрөлхтний хөгжил шинэ шатанд хүрч, технологийн хурдацтай дэвшил, мэдээллийн тасралтгүй урсгал, харилцан уялдаатай нийгмийн харилцаа эрчимтэй өрнөж буй эрин үе юм. Энэ зууны мөн чанар, хөгжлийн онцлогийг эрдэмтэд, судлаачид олон талаас нь тодорхойлж, тайлбарлах оролдлого ирсэн. Тухайлбал, XXI зууныг “мэдээллийн технологийн дэвшил дээр суурилсан, сүлжээ хэлбэртэй нийгмийн зуун” (Castells, 2010, p. vii), “хүн төрөлхтөн хэн болох, юунд итгэх, юу руу тэмүүлэхээ эргэцүүлж буй оюун санааны сорилтын зуун” (Naragi, 2018, p. 326), “уур амьсгалын өөрчлөлт, тэгш бус байдал, байгалийн нөөцийн хомсдол зэрэг асуудлыг шийдвэрлэх хариуцлага хүн төрөлхтөнд ноогдож буй зуун” (Sachs, 2015, p. 2), “амьдралын хэв маяг, хөдөлмөр эрхлэлт, харилцаанд суурь өөрчлөлт авчрах технологийн хувьсгалын ирмэг дээр (Schwab, 2016, p. 1) ирснийг онцолж байна. Энэхүү хувьсан өөрчлөгдөж буй бодит нөхцөл байдал нь боловсрол, соёл, шинжлэх ухаан төдийгүй нийгмийн бүх салбарт шинэ сорилт, боломж, хөгжлийн чиг хандлагыг бий болгож байна

Эдгээр онцлог нь нэг талаас, хүн төрөлхтөнд олон боломжийг нээхийн байгаа боловч, нөгөө талаас, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал, олон төрлийн ялгаварлан гадуурхалт, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, энх тайван байдалтай холбоотой олон талт сорилт, асуудлыг хурцатгаж байна. Ийм нөхцөлд таамаглах боломжгүй, тасралтгүй хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд хүмүүс хамтдаа амьдарч, ажиллаж, оршин тогтохын тулд бидэнд ямар мэдлэг, ур чадвар, туршлага, үнэт зүйлс шаардлагатай, тэдгээрийг хэрхэн эзэмшиж, өөриймшүүлбэл зохистойг тодорхойлох, судлах хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Иймд боловсролын өөрчлөлтийг зөвхөн бодлогын шинэчлэл бус, харин философи суурьтай парадигмын өөрчлөлт хэмээн тайлбарлах онолын шаардлага тулгарч байна. Энэ нь *нэг талаас*, боловсролын парадигмын философи үндэслэлийг дахин нягтлан эргэцүүлэх

онолын шаардлагыг бий болгож, *нөгөө талаас*, боловсролын тогтолцоог бүхэлд нь эргэн харах замаар ХХI зууны нөхцөлд нийцсэн боловсролын шинэ парадигмыг тодорхойлох суурь нөхцөл болж байна. Иймээс уг судалгааны зорилго нь олон улсын боловсролын бодлого, үзэл баримтлалын баримт бичгүүдэд философи шинжилгээ хийж, ХХI зууны боловсролын парадигмыг тодорхойлж буй философи үндэслэлийг илрүүлэхэд оршино.

Парадигм хэмээх ойлголтын утга холбогдол. Энэхүү судалгааны тулгуур ойлголт болох “парадигм” хэмээн ойлголтын утга, холбогдлыг товч авч үзье. “Парадигм” хэмээх ойлголтыг шинжлэх ухааны философийн хүрээнд анх онолын түвшинд тодорхойлсон хүн бол Америкийн философич Т.Кун (1922-1996) юм. Тэрээр шинжлэх ухааны хөгжлийг тайлбарлахдаа парадигм болон түүний солигдлын үйл явцыг гол ойлголт болгон авч үзсэн. Куны тодорхойлсноор “Парадигм нь шинжлэх ухааны нийгэмлэгт тодорхой хугацаанд хүлээн зөвшөөрөгдөж, цаашдын практикийн үндэс суурь болж буй шинжлэх ухааны нэг юм уу, хэд хэдэн шинжлэх ухааны ололт, амжилтад тулгуурласан судалгааны цогц юм” (Kuhn, 1970, p. 10). Иймд “Парадигмаа тодорхойлохгүйгээр ямар нэгэн шинжлэх ухаан хэвийн байх боломжгүй” (Kuhn, 1970, p. 37) гэж онцолсон байдаг.

Кун парадигмыг тодорхой сэдэв, агуулгаас илүүтэйгээр тухайн салбарт ажиллаж буй мэргэжлийн нийгэмлэгийн судалгааны үйл ажиллагааг чиглүүлэгч онол, арга зүй, стандартын нэгдэл хэмээн тайлбарладаг. Учир нь “Судлаачид онол, арга зүй, стандартуудыг уялдаа холбоонд нь нэгдэл байдлаар зэрэг эзэмшдэг” (Kuhn, 1970, p. 15) бөгөөд тухайн парадигмын хүрээнд судалгааны асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, үр дүнг үнэлэх үйл ажиллагаа явуулдаг. Иймээс шинжлэх ухааны хөгжил нь *нэг талаас*, шинжлэх ухаанд итгэл үнэмшил, үнэлэмж, техник хэрэгсэл, арга барил зэргийн багтаасан онол-арга зүйн нэгдмэл загвар болох парадигм болон шинжлэх ухааны нийгэмлэгийн хүлээн зөвшөөрөл, зөвшилцөлтэй салшгүй холбоотой гэж Кун үзсэн байна.

Парадигм нь шинжлэх ухааны философи болон шинжлэх ухаан судлалын үндсэн ойлголтын нэг бөгөөд түүний хэрэглээ, тайлбарын хүрээ ХХ–ХХI зууны онолын эрэл хайгуулын нөлөөгөөр өргөжин тэлж, олон талт утга агуулгатай цогц ойлголт болон төлөвшжээ. Сүүлийн үед эрдэмтэн, судлаачид парадигмын мөн чанар, үүрэг, өөрчлөлтийн механизмийг өөр өөр өнцгөөс тайлбарлаж, түүнийг шинжлэх ухааны онол төдийгүй философи, арга зүй, танин мэдэхүй, үнэт зүйлийн түвшинд нэгдэл хэмээн үзэх нь нийтлэг болж байна. Тухайлбал, Оросын философич В.С.Стёпин (1934-2018) “*Шинжлэх ухааны философи: Ерөнхий асуудлууд*”(2006) бүтээлдээ шинжлэх ухааны хувьсгалын мөн чанарыг тайлбарлахдаа “арга зүйн парадигм” хэмээх ойлголтыг дэвшүүлсэн. Тэрээр арга зүйн парадигмыг тухайн түүхэн үед шинжлэх ухаанд давамгайлж буй судалгааны хандлага, онолын баримжаа, арга зүйн суурь тогтолцоо хэмээн тодорхойлж, онол, судалгааны арга, үнэлэмж, философийн чиг хандлагын цогц хэмээн тайлбарлажээ. Стёпины үзлээр шинжлэх ухааны парадигм нь гурван түвшний суурь бүтэцтэй. Үүнд, 1/ судалгааны үзэл баримтлал, хэм хэмжээ; 2/ ертөнцийн тухай шинжлэх ухааны зураглал; 3/философийн үндэслэлүүд орно. Эдгээрээс философийн үндэслэл нь “Шинжлэх ухааны үзэл баримтлал, хэм хэмжээ, ертөнцийн тухай шинжлэх ухааны зураглалын агуулгын аль алиныг нь зөвтгөдөг философийн үзэл санаа, үндэслэлүүд багтдаг бөгөөд шинжлэх ухааны мэдлэгийг соёлд нэвтрэх боломжийг олгодог” (Стёпин, 2006, стр. 204) суурь үзэл санаа хэмээн тодорхойлогддог.

Оросын философич Тюплина Ирина Анатольевна Парадигмыг “танин мэдэхүйн асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэх суурь үзэл баримтлалын логик схем” (Тюплина И.А., 2014, стр. 161) хэмээн тодорхойлж, онол бүр өөрийн гэсэн парадигмд тулгуурлан оршдог гэж үздэг. Тэрбээр мөн парадигмын өөрчлөлт гэдэг нь онолын суурь логик схемийн солигдолтыг илэрхийлэх бөгөөд уг шинэ парадигм нь шинжлэх ухаан эсвэл

танин мэдэхүйн арга зүйн үндэс болж чадсан тохиолдолд шинжлэх ухаанд хувьсгалт өөрчлөлт авчирдаг (Тюплина И.А., 2014, стр. 161) болохыг онцлон тэмдэглэжээ.

АНУ-ын эрдэмтэн Донна М. Мертенс (Donna M. Mertens) “Парадигм нь зөвхөн онол төдийгүй философийн суурь хандлага, үнэлэмж, танин мэдэхүйн байр суурь, ёс зүйн талаарх таамаглалыг агуулсан цогц тогтолцоо” (Mertens, 2012, p. 256) гэж тодорхойлсон. Түүний үзлээр судлаачийн дотоод итгэл үнэмшил, философийн байр суурь нь судалгааны арга зүйн сонголт, судалгааны бүтцэд шууд нөлөөлдөг тул парадигм нь судалгааны өмнөх, суурь философи хүрээ болдог. Иймээс парадигмын өөрчлөлт нь арга зүйн өөрчлөлтөөс өмнө өрнөдөг философи, үнэт зүйн түвшний шилжилт бөгөөд энэ нь судалгааны шинэ хандлага, шинэ бүтцийг бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг гэж үзжээ. Доун Фрэншотер, Жэйн Кахилл (Dawn Freshwater, Jane Cahill) нар “Парадигмыг зөвхөн арга зүй эсвэл өгөгдлийн төрөлтэй (чанарын, тоон) холбох нь хэт ерөнхийлсөн, утга агуулгыг тодорхойгүй ойлголт болж байна” (Cahill, 2013, p. 4). Тэдний үзлээр парадигм нь арга зүйгээс давсан, философийн суурь хандлага, мэдлэг бүтээх логик, үнэт зүйн чиг баримжааг хамарсан уян хатан тогтолцоо байх ёстой гэж үзсэн. Иймээс парадигмын өөрчлөлт нь нэг арга зүйгээс нөгөөд шилжих явдал бус, харин нөхцөл байдал, харилцан хамааралд дасан зохицох чадвартай, хувьсан шинэчлэгдэх философи тогтолцооны өөрчлөлт гэж тэд дүгнэжээ.

Харин Петер Кохут (Peter Kohut) “Парадигмыг зөвхөн онол төдийгүй мэдлэг бүтээх арга зүй, философийн хандлага, судалгааны логикийг хамарсан өргөн хүрээний үзэл баримтлал” (Kohut, 2017, p. 753) хэмээн тодорхойлсон. Түүний тайлбараар “Парадигм нь бодит байдлын бүхэллэг мөн чанарыг оюун ухаанаар танин мэдэх чадвартай, ирээдүйн шинжлэх ухаан ба философийн үндэс болох диалектик нэгдлийн зарчимд тулгуурласан байх ёстой” (Kohut, 2017, p. 761). Энэ нь бодит байдлын материаллаг болон сэтгэлгээний түвшинд түүний нэгдмэл мөн чанарыг илрүүлж чадахуйц ирээдүйн шинжлэх ухаан ба философийн үндэс болох үндсэн ойлголт, диалектик зарчим, арга зүйд суурилсан шинэ парадигм байх ёстой бөгөөд энэ нь хүний мэдлэгийн түүхэн хувьслын гараа болж өгдөг гэж Кохут үзжээ. Жэймс Хэйвүүд Роллинг Жуниор (James Haywood Rolling Jr) “Парадигм нь шинжлэх ухааны нийгэмлэгийн нийтлэг ойлголт, хамтын итгэл үнэмшил, судалгааны шийдлүүдийг илэрхийлэх замаар амжилттай хөгждөг” (James Haywood Rolling, 2020, p. 356). “Парадигмаа алдана гэдэг нь “диваажинг” алдсантай адил зүйл биш, харин эсрэгээрээ, хуучин парадигмуудаас салах нь шинэ бөгөөд нээлттэй мэдээллийг хүлээн зөвшөөрөх эхлэл байж болох юм” (James Haywood Rolling, 2020, p. 359) хэмээн тайлбарлажээ.

Эдгээр эрдэмтэн, судлаачийн тайлбар, дүгнэлтийг нэгтгэн харвал, парадигм, парадигмын өөрчлөлтийн талаар нийтлэг хэд хэдэн үзэл санааг дэвшүүлсэн байна. Тодруулбал, парадигм нь тухайн цаг үед нийгмийн болон шинжлэх ухааны нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдсөн онолын суурь, арга зүйн баримжаа, философийн хүрээ болон суурь хандлагыг багтаасан нэгдмэл тогтолцоо болохыг онцолж байна. Энэхүү тогтолцоо нь үнэт зүйл, итгэл үнэмшилд тулгуурлан тогтож, судалгааны арга зүй, мэдлэг бүтээх үйл явц, бодит байдлыг тайлбарлах логикийг чиглүүлдэг гэж үзсэн байна. Мөн үүний зэрэгцээ парадигм нь хөдөлшгүй бус, харин нийгэм, шинжлэх ухааны хөгжил, шинэ мэдлэг, хуримтлагдсан зөрчлийн нөлөөгөөр шинэчлэгдэж, солигддог динамик шинжтэй үзэгдэл болохыг онцолж байна.

Судлаачдын парадигмын дээрх нийтлэг үзэл санаа, шинжид тулгуурлан “Парадигм” хэмээх ойлголтыг тухайн цаг үед шинжлэх ухааны түвшинд эрдэмтдийн нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдсөн онолын суурь, судалгааны арга зүй, үнэт зүйлсийг нэгтгэсэн философи баримтлал гэж тодорхойлж болно. үндэслэн энэхүү судалгаанд “Боловсролын парадигм”-ыг тухайн цаг үед боловсролын хүрээнд эрдэмтэн, судлаачид болон багш мэргэжилтнүүдийн нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдсөн онолын суурь, сургалт-судалгааны арга зүй, боловсролын үнэт зүйлсийг нэгтгэсэн философи баримтлал гэж үзэв. Боловсролын

парадигм нь тухайн нийгэмд зонхилж буй сэтгэлгээний хэв маяг, хүний хөгжлийн тухай ойлголт, шинжлэх ухаан, философийн түвшний суурь үнэт зүйлсийг илэрхийлж байдаг бөгөөд тухайн цаг үеийн онцлог, нийгмийн хэрэгцээ шаардлага, соёлын нөлөөтэй уялдан өөрчлөгддөг.

XXI зууны боловсролын парадигм. XXI зууны боловсролын парадигмын мөн чанар, өөрчлөлтийг тайлбарласан судалгааны зарим бүтээлийг товч авч үзье. Үүнд, Польшийн боловсрол судлаач, философич Татьяна Кравчинска-Зауха “*XXI зуунд шаардлагатай боловсролын философи ямар байх ёстой вэ?*” өгүүлэлдээ XXI зууны боловсрол нь тогтсон мэдлэгийг дамжуулахад чиглэх бус, харин “хүний чөлөөт хөгжил, бүтээлч байдал, авьяасыг дэмжиж, хүнийг эрх чөлөөтэй, хариуцлагатай, өөрийн оршихуйн утгыг өөрөө бүтээх субъект гэж үзэх хэрэгтэй бөгөөд дижитал эрин ба VUCA ертөнцөд бэлтгэх” (Tatiana Krawczyńska-Zaucha, 2020, p. 468) ёстойг онцолсон байна. Харин энэхүү боловсролын нь “насан туршийн суралцахуй, дасан зохицох чадвар, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэх ёстой” (Tatiana Krawczyńska-Zaucha, 2020, p. 477) гэж дүгнэсэн байдаг. Түүний үзэж байгаагаар боловсрол авторитар загвараас хувь хүн төвтэй, уян хатан, интегратив загвар руу шилжиж байна гэжээ.

АНУ-ын боловсрол судлаач, боловсролын философич Карл Эдвин Линдгрены “*Боловсролын парадигмын өөрчлөлт*” өгүүлэлд XXI зууны боловсрол нь хүний ёс суртахуун, нийгмийн ухамсар, бүтээлч байдал, бие-оюуны тэнцвэрийг нэгдмэл байдлаар хөгжүүлэхийг шаардаж байна. Тэрээр “Technoman” буюу технологид түшиглэсэн хүний шинэ орчинд боловсрол нь технологийг нэгтгэхийн зэрэгцээ хүмүүнлэгийн үнэт зүйлс, нийгмийн хариуцлагаа хадгалах ёстойг онцолжээ. Үүний зэрэгцээ “боловсролын өөрчлөлт нь энгийн хувьслын шинжтэй бус, харин сэтгэлгээ, үнэт зүйлийн түвшинд өрнөдөг “оюун санааны хувьсгал”-ын үр дүнд явагддаг (Lindgren, 2013, pp. 4-10) гэж дүгнэсэн байна. Мөн тэрээр XXI зууны боловсролын парадигм нь технологийг уян хатан нэгтгэхийн зэрэгцээ хүмүүнлэгийн үнэт зүйл, нийгмийн хариуцлага, бүтээлч сэтгэлгээ, насан туршийн суралцахуйг хөгжүүлэх интегратив шинэ загвар болохыг онцолжээ.

Оросын нэрт боловсрол судлаач, философич М.И.Мухин “*XXI зууны боловсролын парадигмын тухай асуудалд*” өгүүлэлдээ XXI зууны боловсролын философийн суурь үзэл баримтлалыг гуманизм гэжээ. “Боловсрол нь сурагчийг объект бус, бүтээлч, эрх чөлөөтэй субъект гэж үзэх шаардлагатай. Боловсролын ирээдүйн хөгжлийг тодорхойлох гол өөрчлөлт бол технократ чиглэлээс хүмүүнлэг чиглэл рүү шилжих явдал (М. И. Мухин, 2021, стр. 60-62) гэж үзжээ. Судлаачийн дүгнэснээр, суралцагчийн онцлог, хэрэгцээнд нийцсэн сургалтын арга зүй нь хүмүүнлэг боловсролын парадигмын цөм элемент бөгөөд шинэ парадигм нь ёс суртахуун, нийгмийн хариуцлага, экологийн ухамсар, хүний эрх, эрх чөлөө, бүтээлч чадварыг эн тэргүүнд тавьсан үнэт зүйлийн шилжилтийг илэрхийлдэг байна.

Эндээс харахад, XXI зууны боловсролын онцлогийг дараах байдлаар тодорхойлж байна. Тодруулбал,

- Боловсролын гол утга нь хүнийг дээд үнэт зүйл гэж үзэхэд оршино. Хүн бол боловсролын зорилго төдийгүй хэрэгжүүлэгч, утга бүтээгч бөгөөд эрх чөлөө, хариуцлага, өөрийгөө хөгжүүлэх боломжийг хүндэтгэх нь боловсролын суурь зарчим гэж үзсэн байна.
- Боловсрол нь зөвхөн хувь хүний хөгжлийг дэмжих төдий бус, нийгмийн хамтын сайн сайхны төлөө хариуцлагатайгаар орших ухамсар, соёлыг төлөвшүүлэх үйл явц болохыг онцолсон байна.
- Боловсролын зорилго нь тогтсон мэдлэг дамжуулахад бус, харин бие даан суралцах чадвар, шүүмжлэлт ба бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх насан туршийн суралцахуйг дэмжихэд оршино. Технологийн хурдацтай хөгжил дунд боловсролын тогтолцоо нь

хүний ёс зүй, соёл, үнэт зүйлийг хадгалан хамгаалж, шинэ нөхцөлд уялдан хөгжих уян хатан, тасралтгүй шинэчлэгддэг тогтолцоо хэмээн судлаачид үзсэн байна.

Мөн боловсролын парадигмын философи үндэслэлийг дахин нягтлан эргэцүүлэх онолын хэрэгцээ тулгарч байгааг онцолж байна.

Сүүлийн жилүүдэд боловсролын талаар олон улсын хэмжээнд олон хэлэлцүүлэг өрнөж, үзэл баримтлал, бодлогын шинжтэй баримт бичиг, бүтээлүүд гарсаар байна. Эдгээрт ЮНЕСКО, ЭЗХАХБ, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг олон улсын байгууллагуудаас Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь: Боловсрол бүх нийтийн баялаг мөн үү? (2015), Боловсрол 2030: Инчеоны тунхаглал (2015), Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ (2021), Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас “Суралцахуйн хүрээ 2030” (2018), Дэлхийн эдийн засгийн форум (WEF)-оос аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын үеийн боловсрол “Боловсрол 4.0” (2020), ЮНЕСКО “Тогтвортой хөгжлийн боловсрол: Замналын зураглал” (2020) зэрэг баримт бичгийг нэрлэж болохоор байна. Эдгээр баримт бичигт:

- *Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь: Боловсрол бүх нийтийн баялаг мөн үү? баримт бичигт* “Бид өнгөрсөн үедээ хийсэн задлан шинжилгээний үр дүнд үндэслэн ирээдүйн боловсрол ба сурах үйл ажиллагааг төсөөлж, шинээр тодорхойлох ёстой” (ЮНЕСКО, 2017, хууд. 14).
- *Боловсрол 2030: Инчеоны тунхаглалд* “Даяаршил, технологийн хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, хүн амын хөдөлгөөнт байдал зэрэг шинэ нөхцөл байдал, сорилт нь боловсролын зорилго, агуулгыг шинэчлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна” (UNESCO, 2016, р. 8).
- *Тогтвортой хөгжлийн боловсрол: Замналын зураглалд* “Бид юуг мэддэг, юунд итгэдэг, юу хийдгээ өөрчлөх хэрэгтэй болж байна. Өнөөг хүртэл сурч мэдсэн зүйл маань биднийг сорилтод бэлтгэж чадаагүй байна”, “Тогтвортой ирээдүй рүү шилжихийн тулд бид ухаалаг шийдвэр гаргах, орон нутгийн, үндэсний болон дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хэрэгцээтэй мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагаа хөгжүүлэхэд юуг, хаана, яаж хийх талаар эргэж нэг эргэцүүлэх хэрэгтэй байна” (ЮНЕСКО, 2020, хуудсд. 6,8).
- *Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээнд* “Өнөөдөр хүн төрөлхтний өнөө болон ирээдүйд, амьд гараг-эх дэлхийд тулгараад байгаа ноцтой эрсдэлүүд нь эдгээр эрсдэлийг даван туулахад бидэнд тусалж чадахуйц боловсролын талаар эргэцүүлэн тунгааж, нэн яаралтайгаар шинээр төсөөлөх хэрэгцээ буй болоод байна. Энэ нь “Бид юуг цаашид үргэлжлүүлэн хийх ёстой вэ?”, “Бид юунаас татгалзах ёстой вэ?”, “Бид юуг цоо шинээр бий болгох хэрэгтэй вэ?” (ЮНЕСКО, 2022, р. 2)

Эндээс харахад, баримт бичгүүдэд өнгөрснөө шинжлэн дүгнэж, бид юуг үргэлжлүүлэх, юунаас татгалзах, юуг шинээр бүтээхээ шийдвэрлэн, мэдлэг, үнэт зүйл, үйлдлийн түвшинд өөрчлөлт хийх шаардлагатай байгааг онцолж байна. Энэ нь боловсролын тогтолцоонд үүсээд буй зөрчил, хямралыг илтгэн харуулж байгаа бөгөөд Томас Куны тодорхойлсон “парадигмын хямрал”-ын шинжийг илэрхийлж байна. Куны үзлээр шинжлэх ухааны хөгжлийн хэвийн үе шатанд хуримтлагдсан аномали буюу хуучин парадигмд үл нийцэх үзэгдэл, баримтууд олшрох тусам онолын тогтолцоо хямралд орж, шинэ парадигм бий болох нөхцөл бүрддэг хэмээн үздэг. Энэ онолын логикоор авч үзвэл, өнөөгийн боловсролын байдал нь хуучин парадигм бодит нөхцөл байдлыг бүрэн тайлбарлах боломжоо алдаж, парадигмын хямралд орон, шинэ парадигм руу шилжих өөрчлөлт өрнөж буйг харуулж байна.

ЮНЕСКО-оос боловсруулсан баримт бичгүүд нь хуучин парадигмаар тайлбарлах боломжгүй асуудлуудыг шинэ үнэт зүйл, үзэл санаа, арга зүйгээр тодорхойлох зорилго дэвшүүлсэн, тодхуулбал, боловсролын шинэ парадигмыг илэрхийлэл болсон гэж үзэж болно.

Боловсролын олон улсын баримт бичигт хийсэн философи шинжилгээ. Энэхүү философи шинжилгээнд ЮНЕСКО-оос гаргасан “Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь: Боловсрол бүх нийтийн баялаг мөн үү?”, “Тогтвортой хөгжлийн боловсрол: Замналын зураглал”, “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ” гэсэн баримт бичгүүдийг сонгон шинжлэх үндэслэл нь нэгдүгээрт, XXI зууны боловсролын парадигмыг тодорхойлж буй суурь баримт бичгүүд гэдэгт, хоёрдугаарт, хүний оршихуй, хамтын ирээдүй, нийгмийн гэрээг боловсролоор дамжуулан шинээр төсөөлж, тодорхойлохыг зорьсон философийн цогц үзэл баримтлал агуулж байгаад оршино. Мөн НҮБ болон ЮНЕСКО-гийн гишүүн бүх улс оронд хамааралтай, тэдгээр улс орны боловсролын бодлого, хууль боловсруулахад суурь үзэл санаа болдог.

Энэхүү философи шинжилгээний зорилго нь XXI зууны боловсролын парадигм, чиг хандлагыг илрүүлэхэд оршино.

Хүснэгт 2. Шалгуур ба баримт бичгийн холбогдох агуулга

<i>Шалгуур</i>	<i>Боловсролын тухай дахин эргэцүүлэх нь: Боловсрол бүх нийтийн баялаг уу? (2015)</i>	<i>“Тогтвортой хөгжлийн боловсрол: Замналын зураглал 2030” (2020)</i>	<i>Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ (2021)</i>
<i>Философийн антропологи</i>	- Хүн бол өөрийгөө хөгжүүлэх, нийгмийн өөрчлөлтөд оролцох, хамтын ирээдүйг бүтээх чадамжтай оршихуй. - Хүн бол ёс суртахуунтай, эрх чөлөөтэй, хариуцлагатай субъект.	- Хүн бол байгальтай хамт амьдрах чадвартай, нийгмийн сайн сайхны төлөө хариуцлага хүлээдэг оршихуй. - Хүн өөрийгөө болон орчноо өөрчилж, шинээр бүтээх чадамжтай, ёс суртахуунтай, оролцоотой субъект.	- Хүн бол ёс суртахуунтай, эрх чөлөөтэй, хариуцлагатай, хамтын оршихуйтай субъект. - Хүн нь өөрийгөө хөгжүүлэгч ба нийгмийн өөрчлөлтийн оролцогч - “Ирээдүйг хамтдаа төсөөлөх, бүтээх” эрхтэй төдийгүй үүрэгтэй субъект
<i>Онтологи</i>	- Байгаль, нийгэм, технологи, соёл нь харилцан хамааралтай, сүлжилдсэн, олон төвтэй ертөнц. - Дэлхий бол нэгдмэл боловч тогтворгүй, өөрчлөгдөж буй, эрсдэлтэй орон зай.	- Хүн, нийгэм, байгаль, соёл, эдийн засаг, технологи нь уялдаа холбоотой, харилцан хамааралтай нэгдмэл тогтолцоо. - Хамтын оршихуй нь тогтворгүй, эрсдэлтэй, өөрчлөмтгий.	- Дэлхий бол бидний хамтын орон зай. - Байгаль, нийгэм, технологи, соёл нь харилцан хамааралтай, олон төвтэй, хамтын оршихуй. - Оршихуй нь дасан зохицол, өөрчлөлт, тодорхой бус ирээдүйг дагуулсан нэгдмэл тогтолцоо.
<i>Гносеологи</i>	- Мэдлэг бол утга бүтээх, шүүмжлэлтэй сэтгэх, үйлдэлд	- Мэдлэг нь сэтгэл хөдлөл, ёс суртахуун, зан үйлийн нэгдэл.	- Мэдлэг нь олон талт, туршлагад суурилсан, нээлттэй процесс.

	чиглэсэн, хамтран суралцах үйл явц. - Мэдлэг нь дэлхийн олон соёл, туршлагыг багтаасан нээлттэй систем.	- Мэдлэг нь хамтын ажиллагаа, үйлдэлд чиглэсэн насан туршийн үйл явц. - Танин мэдэхүйн зорилго нь харилцан уялдаатай асуудлыг ойлгох, хувиргалт хийх явдал.	- Мэдлэг бол нийгмийн шударга ёсыг хангах хэрэгсэл. - Мэдлэг нь хамтын үйл ажиллагаагаар бүтээгдэж, өөрчлөгддөг насан туршийн суралцахуй.
<i>Аксиологи</i>	- Хүний эрх, нэр төр, ёс суртахуун, эмпати, энэрэл, итгэлцэл, хүндлэл - Олон янз байдал, эв нэгдэл, шударга ёс, энх тайван, хамтын хариуцлага, хамтын сайн сайхан - Боловсрол, мэдлэг бол дэлхий нийтийн баялаг, үнэт зүйл	- Хүний эрх, тэгш байдал, - Шударга ёс, байгальд ээлтэй амьдралын хэв маяг - Соёлын олон янз байдал, хамтын хариуцлага, хамтын ирээдүй, хамтын сайн сайхан, тогтвортой хөгжил	- Хүний эрх, нэр төр, тэгш боломж эмпати, итгэлцэл, хүндлэл - Олон янз байдал, харилцан ойлголцол, шударга ёс, энх тайван, эв нэгдэл - Хамтын шийдвэр гаргалт, хамтын хариуцлага, хамтын сайн сайхан

Эдгээр баримт бичгийн агуулгад антропологи, онтологи, гносеологи, аксиологи гэсэн философи шалгуурын дагуу хийсэн шинжилгээнд үндэслэн (хүснэгт 2) ХХI зууны боловсролын парадигмын философи үндэслэлийг тодруулж байна. Үүнд:

Философийн антроплогийн хувьд, хүнийг ёс суртахуунтай, эрх чөлөөтэй, хариуцлагатай, хамтын оршихуйтай субъект бөгөөд өөрийгөө болон орчноо ухамсартайгаар өөрчилөн, нийгмийн сайн сайхны төлөө хамтдаа үйлдэж, ирээдүйг хамтдаа бүтээх чадамжтай оршихуй хэмээн тодорхойлж байна.

Онтологийн түвшинд, оршихуйг нийгэм, соёл, байгаль, технологийн харилцан хамаарал бүхий олон төвт, динамик тогтолцоо хэмээн үзэж байна. Энэ нэгдмэл тогтолцоо нь тодорхой бус ирээдүйд дасан зохицох, шинэчлэн өөрчлөгдөх боломж ба эрсдэлийг зэрэгцүүлэн агуулдаг гэж тодорхойлж байна. Энэ нөхцөлд боловсролыг уг харилцан хамаарлыг ухамсарлах, хамтран суралцах, хамтын оршихуйг төлөвшүүлэх замаар тогтвортой ирээдүйг бүтээх үндсэн хэрэгсэл гэж үзэж байна.

Гносеологийн хувьд, мэдлэгийг хамтын оролцоо, шүүмжлэлтэй сэтгэлгээ, туршлага, утга бүтээх үйлд тулгуурласан, нээлттэй бөгөөд үйлдэлд чиглэсэн, тасралтгүй үргэлжлэх насан туршийн суралцах үйл явц хэмээн тодорхойлж байна. Танин мэдэхүйн зорилго нь бодит асуудлыг уялдаа холбоотойгоор ойлгож, утга шинээр бүтээх замаар нийгмийн шударга ёс, хамтын сайн сайхны төлөө чиглэсэн бүтээх үйлдэлд хүргэхэд оршиж байна. Иймд боловсрол нь мэдлэгийг дамжуулах бус, харин мэдлэгийг хамтдаа бүтээж, үйлдлээр баталгаажуулан хувь хүн болон нийгмийн хөгжлийг чиглүүлэх үйл явц хэмээн шинээр тодорхойлогдож байна.

Аксиологийн түвшинд, хүний эрх, нэр төр, тэгш байдал, шударга ёс, хамтын сайн сайхан, хариуцлага, олон янз байдал, харилцан ойлголцол, итгэлцэл, энх тайван, тогтвортой хөгжил зэргийг суурь үнэт зүйл болгон дэвшүүлж байна. Үүний зэрэгцээ ялгаварлан гадуурхахгүй байх, нийгмийн шударга бүтэц бүрдүүлэх, байгаль орчны болон нийгмийн тогтвортой

байдлыг хангах гэсэн нийгмийн үнэт зүйлсийг итгэлцэл, ойлголцол, сэтгэл хөдлөл, ёс суртахуун гэсэн хувь хүний эрхэмлэлтэй уялдуулан авч үзжээ.

XXI зууны боловсролын парадигмын философи үндэслэлүүд философийн аль урсгал, чиглэлийн үзэл санаанд тулгуурлаж байгааг хүснэгт 3-аар нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 3. XXI зууны боловсролын философи үндэслэл ба суурь үзэл санаа

№	Философи үндэслэл, агуулга	философийн чиг хандлага
Философийн антропологи	Хүнийг эрх чөлөөтэй, хариуцлагатай, утга бүтээгч оршихуй.	Экзистенциализм
	Хүн өөрийгөө болон орчноо ухамсартайгаар өөрчилдөг оршихуй.	Феноменологи
Онтологи	Оршихуй нь хүн, нийгэм, соёл, байгаль, технологи зэрэг хоорондоо уялдаа холбоо, харилцан хамаарал бүхий нэгдмэл тогтолцоо.	Синергетик
	Оршихуйн нь олон төвт, динамик тогтолцоо.	Синергетик, Постмодернизм
Гносеологи	Мэдлэгийг нээлттэй, туршлагад суурилсан динамик үйл явц.	Прагматизм Герменевтик
	Мэдлэг нь оролцоо, шүүмжлэлд тулгуурласан утга учир бүтээх үйл явц.	Герменевтик
	Мэдлэг бол үйлдэлд чиглэсэн, тасралтгүй үргэлжлэх насан туршийн суралцах үйл явц	Прагматизм
Аксиологи	Хүний эрх, нэр төр, энэрэл, итгэлцэл	Феноменологи
	Шударга ёс, тэгш байдал, хамтын сайн сайхан, хамтын хариуцлага, энх тайван, тогтвортой хөгжил	Прагматизм Синергетик

Дүгнэлт. Философи шинжилгээний үр дүнд тулгуурлан XXI зууны боловсролын парадигмын философи үндэслэл, хөгжлийн чиг хандлагын талаар дараах дүгнэлтүүдийг хийх боломжтой байна. Үүнд,

Нэгт, XXI зууны боловсролын парадигмын философийн үндэслэл нь сонгодог бус болон сонгодог бусын дараах философийн урсгал, чиглэлийн үзэл санаа болон тэдгээрийн интеграцид тулгуурлаж буй нь тодорхой байна. Тодруулбал, философийн антропологийн түвшинд экзистенциализм ба феноменологийн хүний оршихуйг тайлбарлах үзэл санаа; онтологийн түвшинд синергетикийн өөрөө зохион байгуулагдах нээлттэй системийн үзэл санаа; гносеологийн түвшинд прагматизм ба герменевтикийн мэдлэг бүтээх, утга тайлах арга зүй; харин аксиологийн түвшинд феноменологи ба прагматизмын үнэт зүйлийн талаарх үзэл санаанд суурилсан болох нь харагдаж байна.

Хоёрт, XXI зууны боловсролын парадигм нь систематик хандлага (нэгдмэл логик бүхий бүтцэд төвлөрдөг бөгөөд цогц, уялдаа холбоотой, зорилготой системд тулгуурлан судлах), эклектик арга зүйг (олон эх сурвалж, онол, арга барил, үзэл баримтлалаас шилж сонгон хослуулан ашиглах хандлага) ашигласан гэж үзэж болохоор байна. Энэ шинж онцлог нь боловсролын асуудлыг бүрэн, цогц шийдэхийн тулд философийн урсгал, чиглэлүүдээс уян хатан байдлаар сонгон авч, тэдгээрийг нэгтгэн уялдуулж хэрэглэснээс харагдаж байна. Энэ нь боловсролын бодит асуудлуудыг нэг онол, нэг хандлагаар тайлбарлах боломжгүй болсон өнөөгийн нөхцөлд зайлшгүй шаардлагатай арга зүйн сонголт бөгөөд боловсролын парадигмын уян хатан, нээлттэй шинжийг илтгэнэ.

Гуравт, ХХI зууны боловсролын парадигм сонгодог бус болон сонгодог бусын дараах философийн урсгал, чиглэлүүдийн үзэл санаанд тулгуурлаж, тэдгээрийн үзэл санааг нэгтгэх чиглэлд өөрчлөгдөж байгаа нь зүй ёсны хэрэг юм. Учир нь боловсролын парадигмын өөрчлөлт нь зөвхөн бодлогын шинэчлэл бус, харин шинжлэх ухаан, философийн түвшинд давамгайлж буй ертөнцийг үзэх үзэл, мэдлэгийн шинж чанарын тухай ойлголт, үнэт зүйн баримжааны өөрчлөлттэй шууд холбоотой юм. Сонгодог бусын дараах философид ертөнцийг нээлттэй, өөрөө зохион байгуулагдах, олон хувилбарт, харилцан хамаарал бүхий динамик систем хэмээн үзэх үзэл санаа нь боловсролын парадигмын өөрчлөлтийг цааш гүнзгийрүүлж байна. Иймээс ХХI зууны боловсролын парадигмын философи үндэслэл нь тогтвортой биш, харин нийгэм, соёл, технологийн өөрчлөлттэй уялдан тасралтгүй шинэчлэгддэг динамик шинжтэй үйл явц болохыг энэхүү судалгаа харуулж байна.

Боловсролын парадигмын философи үндэслэл, суурь үзэл санааг бүрдүүлж буй философийн баримтлалуудаас гадна нийгэм, соёл, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн шинэ шаардлагад нийцсэн үзэл баримтлал, онолууд тасралтгүй шинээр боловсруулагдан хөгжиж байдаг. Тэдгээр философийн баримтлал, онол, чиг хандлага бүрийн бодит үнэ цэнэ нь боловсролын бодлого, практик, судалгаанд хэрхэн хэрэгжиж, хүний хөгжил, нийгмийн сайн сайханд ямар үр нөлөө үзүүлж байгаагаар шалгагддаг. Энэ утгаараа боловсролын парадигм нь тухайн нийгэмд зонхилж буй сэтгэлгээний хэв маяг, хүний хөгжлийн тухай ойлголт, философи, шинжлэх ухааны суурь зарчим, үнэт зүйлсийг илэрхийлсэн түүхэн шинжтэй баримтлал бөгөөд нийгмийн хэрэгцээ, соёлын нөлөө, шинэ үзэл санааны дарамтад оршин тогтнож, өөрчлөгдөн хөгжсөөр байдаг.

Иймээс боловсролын бодлого, практик, судалгаанд нөлөөлж буй философийн олон урсгал, чиглэл, үзэл баримтлалыг өргөн хүрээнд хэлэлцэж, тэдгээрийн уялдаа, зөрүүг тодорхойлох нь боловсролын парадигмын өөрчлөлтийг онолын болон практикийн түвшинд ухамсарлан тодорхойлох, цаашлаад ХХI зууны нөхцөлд нийцсэн боловсролын шинэ парадигмыг боловсруулах арга зүйн суурь нөхцөл болж байна.

The educational paradigm of the 21st century: a philosophical analysis of policy documents

Batzaya Bat-Ulzii 

MA, Lecturer of the Department of Social Sciences,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Abstract. This article explores the philosophical foundations of the twenty-first-century educational paradigm through an analysis of key international education policy documents. The study aims to identify the philosophical assumptions underlying contemporary educational change as articulated in major UNESCO texts, including *Rethinking Education: Towards a Global Common Good?*, *Education for Sustainable Development: A Roadmap 2030*, and *Reimagining Our Futures Together: A New Social Contract for Education*. Employing document-based philosophical analysis that combines hermeneutic interpretation and comparative methods, the research is structured around four analytical criteria: anthropology, ontology, epistemology, and axiology. The findings indicate that the emerging educational paradigm is grounded in a humanistic conception of the learner as a free, responsible, and creative subject. Ontologically, reality is understood as a dynamic and interconnected system linking society, culture, nature, and technology. Epistemologically, knowledge is conceptualized as a collaborative, action-oriented, and lifelong process, while axiologically the paradigm emphasizes human dignity, social justice, equality, peace, and sustainable development. Overall, the study demonstrates that the educational

paradigm of the twenty-first century constitutes a dynamic philosophical framework that responds to global challenges and ongoing societal transformation.

Keywords: educational paradigm, paradigm shift, philosophical foundations of education, philosophical anthropology, *ontology*, gnoseology, axiology

Ном зүй – References

- Cahill, D. F. (2013). Paradigms Lost and Paradigms Regained. *Journal of Mixed Methods Research*.
- Castells, M. (2010). *The rise of the network society* (2nd ed.)
<https://doi.org/10.1002/9781444319514>
- Daria Goldberg, A. D. (2019). Analysis of Modern Education and the Course of Reform. *Advances in Social Science, Education and Humanities Research*, 665.
<https://doi.org/10.2991/iccessh-19.2019.148>
- Gopinath, C. (2012). A systems framework for globalisation. *International Journal of Business and Globalisation*, 316.
- Harari, Y. N. (2018). *21 Lessons for the 21st Century*. Spiegel & Grau.
- James Haywood Rolling, J. (2020). Paradigms Lost. *Studies in Art Education: A Journal of Issues and Research*, 356. <https://doi.org/10.1080/00393541.2020.1820840>
- Jana Kukeska, K. B. (2020). Evolving a New Paradigm in Education Appropriate to the Needs of the 21st Century. *UTMS Journal of Economics*, 59-66.
- Kohut, P. (2017, December). New Paradigm in Philosophy & Science. *Scientific GOD Journal*, 8(10), 752.
- Kuhn, T. S. (1970). *The Structure of Scientific Revolutions*. Chicago: The university of chicago press.
- Lindgren, C. E. (2013). The Evolution of the Educational Paradigm. *European Scientific Journal*. Retrieved from <http://www.worldacademy.org>
- Mertens, D. M. (2012). What Comes First? The Paradigm or the Approach? *Journal of Mixed Methods Research*. <https://doi.org/10.1177/1558689812461574>
- Olga Chistyakova. (2017). Humanitarian-anthropological Aspects of Contemporary Education (Philosophical Analysis). *Advances in Social Science, Education and Humanities Research*, 610-613. <https://doi.org/10.2991/icadce-17.2017.147>
- Reich, S. (1998). What is globalization? Four Possible Answers. The Helen Kellogg Institute for International Studies.
- Sachs, J. (2015). The Age of Sustainable Development. *International Journal of Social Economics*, XVII. Retrieved from ISBN 978-0-231-17315-5
- Schwab, K. (2016). *The Fourth Industrial Revolution*. World Economic Forum.

- Tatiana Krawczyńska-Zaucha. (2020). What is the philosophy of education needed in the XXI century? Culture-Society-Education, 467-478. <https://doi.org/10.14746/kse.2020.18.17.2>
- UNESCO. (2016). Education 2030: Incheon Declaration and Framework for Action .
- WEF. (2023). Defining Education 4.0: A Taxonomy for the Future of Learning.
- Антипин Н.А. (2019). XXI зууны боловсролын философийн үзэл баримтлал-арга зүйн асуудалд. Нэмэхжаргал.Т-Д, Боловсролын философи-арга зүйн асуудал. Улаанбаатар: Битпресс.
- М. И. Мухин. (2021). К вопросу о стержневой основе парадигмы образования XXI столетия. Международный электронный научный журнал. Получено из ISSN 2307-2334
- Стёпин, В. (2006). Философия науки. Общие проблемы. Москва.
- Тюплина И.А. (2014). Развитие представлений о парадигме в философии науки. Научный альманах Странник.
- ЮНЕСКО. (2017). Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь: Боловсрол бүх нийтийн баялаг уу? Улаанбаатар: ШУТИС Хэвлэлийн газар.
- ЮНЕСКО. (2020). Тогтвортой хөгжлийн боловсрол: Замналын зураглал. Улаанбаатар.
- ЮНЕСКО. (2022). Ирээдүйгээ хамтдаа төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ. Улаанбаатар.
- ЮНЕСКО. (2022). Тогтвортой хөгжлийн боловсрол: Замналын зураглал.